



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/17/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2023 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ц.Саранчимэг

Утас: 70273204 Цахим хаяг: Saranchimegtst@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.4.1 Мөнгөн хөрөнгө	11
3.5.2 Авлага	12
3.5.3 Урьдчилгаа.....	13
3.5.4 Бараа материал.....	13
3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө.....	14
3.5.6 Үндсэн хөрөнгө.....	14
3.5.7 Өр төлбөр.....	15
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо	15
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	21
4.1 Ерөнхий зүйл	21
4.2 Материаллаг байдал.....	21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	21
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	21
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	22
4.5.1 Завсрын аудитын талаар	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	22
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	23
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	25

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХАА	Хөдөө аж ахуй
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БНСБС	Байгалийн нөхөн сэргээх барьцаа сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуушмод сум
Утас: 70272582. Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.25 № 01/237
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ
Х.ЦЭРЭНБАТ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Дэлгэрхаан сумын ИТХ-ын тогтоолоор татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг 1,932,472.6 мянган төгрөгөөр баталсан нь аймгийн Татварын хэлтсийн мэдээнээс 1,109,255.6 мянган төгрөгөөр дутуу зөрүүтэй, сумын ИТХ-ын тогтоолоор 13 нэрийн орлого батлагдсанаас гүйцэтгэлээр 8 нэрийн орлого 1,489,462.3 мянган төгрөгөөр тасарсан зэрэг нийт 2,609,196.7 мянган төгрөгийн зөрчил илэрч, тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг", "иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно. Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Дэлгэрхаан сум аймгийн "Түүхт ой-Баялаг байгуулалтыг дэмжих" урианы жилийн хүрээнд болон сум байгуулагдсаны 100 жилийн ойг угтсан 100 бүтээлч ажил, "Ногоон сум" аян, "Тохилог хашаа" болзолт уралдаан, Зууны манлай шагай харваачийн нэрэмжит тэмцээн, малчдын зөвлөгөөн, үе үеийн төгсөгчдийн уулзалт, ахмадын зөвлөгөөн, "Авьаас бидний бахархал", "Нутгийн дууг хэн сайн дуулах вэ" урлагийн наадам, сумын брэнд бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа, айрагны баяр, "Алтан намар", шилмэл мал шалгаруулах арга хэмжээ зэрэг ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлсэн байна.

Төв аймгийн Дэлгэрхаан суманд 2023 онд улс, аймаг, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, хувийн хөрөнгө оруулалтаар дараах ажил хийгдсэн байна. Үүнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сумын шинэчлэл инженерийн дэд бүтцийн ажил 4,000,000.0 мянган төгрөгийн, аймаг, орон нутгийн хөрөнгө оруулалтаар Нутгийн удирдлагын ордны шинэ барилга 1,566,018.1 мянган төгрөгийн, орон нутгийн хөгжлийн сангаар баяр наадмын асар 178,898.5 мянган төгрөгийн, аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалт, хандиваар сумын төвийн өндөрлөг, хаяг, 5-10 ханатай 5 гэр, өв соёлын өргөөний цомцог гэр нийт 121,600.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна.

Аудитын гол асуудал

Дэлгэрхаан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн хоёр дугаар хуралдааны 03 тоот тогтоолоор сум байгуулагдсны 100 жилийн ойн баяр наадам, арга хэмжээнд зарцуулсан хандивын тайланг хэлэлцсэн байна. Энэхүү тогтоолд баяр наадмын хандивын орлогыг Орон нутгийн хөгжлийн санд 168600.0 мянган төгрөг, кассаар 108,600.0 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн байна гэж тогтоосон байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,220,394.0	582,997.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	680,398.3	77,488.6
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	4а, 4б	0.0	0.0
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	356,381.5	408,930.7
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	0.0	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	183,614.1	96,578.4
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	0.0	0.0
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	0.0	0.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,176,788.7	3,250,856.5
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	0.0	0.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	1,176,788.7	3,250,856.5
39200	Биет хөрөнгө		1,175,824.7	3,206,976.6
39300	Биет бус хөрөнгө	13	964.0	43,879.8
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	14	0.0	0.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		2,397,182.7	3,833,854.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		0.0	1,114,372.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	0.0	1,114,372.8
41300	Өглөг	17а, 17б	0.0	1,114,372.8
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		0.0	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		2,397,182.7	2,719,481.3
51	Засгийн газрын хувь оролцоо		2,397,182.7	2,719,481.3
51100	Засгийн газрын оруулсан капитал		579,464.8	579,464.8
51200	Хуримтлагдсан үр дүн		1,506,702.5	1,829,001.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		311,015.4	311,015.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		2,397,182.7	3,833,854.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		3,706,416.0	2,231,390.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО		1,007,454.5	482,417.5
110	Орлогын албан татвар		219,549.5	172,173.2
1100	Хувь хүний орлогын албан татвар		225,295.0	177,918.7
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан		-5,745.6	-5,745.5
113	Хөрөнгийн албан татвар		26,856.2	24,906.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж		761,048.8	285,338.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	566,927.8	776,748.8
120	Нийтлэг татварын бус орлого		566,927.8	604,847.6
122	Тусламжийн орлого		0.0	171,901.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,132,033.7	972,224.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,494,374.7	1,899,630.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,269,731.6	1,303,504.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		980,719.1	1,300,504.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		276,356.7	405,880.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх		39,552.2	56,256.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		328,269.0	45,469.8
2104	Хангамж, бараа материалын зардал		24,448.0	37,026.3
2105	Нормативт зардал		33,362.4	41,600.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		25,980.0	26,000.0
2107	Томилолт, зочны зардал		3,099.5	4,974.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний		73,420.1	20,754.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		176,231.2	662,542.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,289,012.5	3,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		224,643.2	596,125.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		1,212,041.2	331,760.3
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		4,099,936.4	0.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-		-2,887,895.1	331,760.3

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		3,706,416.0	2,223,377.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО		1,007,454.5	474,301.0
110	Орлогын албан татвар		219,549.5	164,056.7
1100	Хувь хүний орлогын албан татвар		225,295.0	171,579.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-5,745.6	-7,522.9
113	Хөрөнгийн албан татвар		26,856.2	24,906.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж		761,048.8	285,338.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	566,927.8	776,852.8
120	Нийтлэг татварын бус орлого		566,927.8	604,951.6
122	Тусламжийн орлого		0.0	171,901.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,132,033.7	972,224.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,494,374.7	1,899,630.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,269,731.6	1,303,504.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		980,719.1	1,300,504.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		276,356.7	405,880.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		39,552.2	56,256.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		328,269.0	45,469.8
2104	Хангамж, бараа материалын зардал		24,448.0	37,026.3
2105	Нормативт зардал		33,362.4	41,600.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		25,980.0	26,000.0
2107	Томилолт, зочны зардал		3,099.5	4,974.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,		73,420.1	20,754.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		176,231.2	662,542.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,289,012.5	3,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		224,643.2	596,125.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		1,212,041.2	323,747.8
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		0.0	0.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		4,099,936.4	0.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-2,887,895.1	323,747.8

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,261,082.6	5,261,082.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	23,995.2	23,995.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,285,077.8	5,285,077.8
9	Тайлант үеийн үр дүн	(2,887,895.1)	(2,887,895.1)
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,397,182.7	2,397,182.7
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,397,182.7	2,397,182.7
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,397,182.7	2,397,182.7
19	Тайлант үеийн үр дүн	331,760.3	331,760.3
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,728,943.0	2,728,943.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,261,550.0	2,287,025.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,370,698.1	993,957.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,367,698.1	990,957.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	416,765.2	385,146.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,095.7	52,631.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	416,309.6	404,846.3
2104	Хангамж, бараа материалын зардал	30,305.7	30,305.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,750.0	40,150.0
2107	Томилолт, зочны зардал	5,638.4	4,974.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	14,646.6	14,333.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	391,186.9	58,570.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,000.0	3,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,000.0	3,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,688,550.1	1,293,068.7
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	202,301.8	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,261,550.0	2,323,757.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	264,042.2	257,432.2
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,529,566.5	1,888,189.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	857,941.3	6,235.1
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	610,000.0	171,901.2
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	-	9,607.4
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	-	46,339.1
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26	26
620001	Удирдах ажилтан	8	8
620002	Гүйцэтгэх ажилтан	10	10
620003	Үйлчлэх ажилтан	3	3
620004	Гэрээт ажилтан	5	5
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	26	26
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11	11
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9	9
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6	6

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	58,436.3	122,663.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	58,436.3	122,663.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	45,647.8	112,055.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	21,046.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	3,313.1
2104	Хангамж, бараа материалын зардал	972.0	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	300.0	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,375.8	87,696.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,788.5	10,608.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,800.0	-
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,988.5	10,608.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	58,436.3	122,663.9
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	58,436.3	122,663.9
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0	0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг дарга Орон нутагтаа бүх шатны хурлын шийдвэр Засгийн газар, аймаг, сумын стратегийн зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, төр засгийн бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлан таниулж, хүн амын эрүүл мэнд, боловсрол, соёл, хөдөлмөр эрхлэлтийн чанарыг ахиулан амьжиргааны түвшнийг дээшлүүлж, төрийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, мал аж ахуй, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлж, сумын эдийн засгийн чадамжийг сайжруулан өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг, Төв аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм.

Дэлгэрхаан сум аймгийн “Түүхт ой-Баялаг байгуулалтыг дэмжих” урианы жилийн хүрээнд болон сум байгуулагдсаны 100 жилийн ойг угтсан 100 бүтээлч ажил, “Ногоон сум” аян, “Тохилог хашаа” болзолт уралдаан, Зууны манлай шагай харваач Ц.Баярбатын нэрэмжит шагайн харвааны тэмцээн, малчдын зөвлөгөөн, үе үеийн төгсөгчдийн уулзалт, ахмадын зөвлөгөөн, “Авьяас бидний бахархал”, “Нутгийн дууг хэн сайн дуулах вэ” урлагийн наадам, сумын брэнд бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа, айрагны баяр, “Алтан намар”, шилмэл мал шалгаруулах арга хэмжээ зэрэг ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлсэн байна.

Төв аймгийн Дэлгэрхаан суманд 2023 онд улс, аймаг, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, хувийн хөрөнгө оруулалтаар дараах ажил хийгдсэн байна. Үүнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сумын шинэчлэл инженерийн дэд бүтцийн ажил 4,000,000.0 мянган төгрөгийн, аймаг, орон нутгийн хөрөнгө оруулалтаар Нутгийн удирдлагын ордны шинэ барилга 1,566,018.1 мянган төгрөгийн, орон нутгийн хөгжлийн сангаар баяр наадмын асар 178,898.5 мянган төгрөгийн, аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалт, хандиваар сумын төвийн өндөрлөг, хаяг, 5-10 ханатай 5 гэр, өв соёлын өргөөний цомцог гэр 121,600.0 мянган төгрөгийн ажил хийгдсэн байна.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай батламж гэрээ байгуулан ажиллаж 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/104 тоот захирамжаар сумдын 2023 оны үйл ажиллагааны үр дүнгийн тухай захирамжаар 91,0 буюу “А” үнэлгээтэй дүгнэгдсэн байна. Сумын ИТХ-ын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 01 тоот тогтоолоор сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 98,42 хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/05 тоот захирамжаар сумын дотоод хяналтын баг томилох тухай шийдвэр 7 хүний бүрэлдэхүүнтэй томилогдсон байна. Дотоод хяналтын төлөвлөгөөг 2023 онд нийт 8 ажил үүрэг гүйцэтгэхээр төлөвлөн батлуулсан байна. Сумын дотоод хяналт шалгалтын баг нь байгууллагуудын өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, анхан шатны баримтын хөтлөлт, бараа материалын зарцуулалт, хөрөнгө оруулалтын ажлын явцын гүйцэтгэл, шилэн дансны

хөтлөлтөд хяналт хийсэн боловч шилэн дансны хуулийн хэрэгжилтийн байдал хангалтгүй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасны дагуу Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичгийг шалгахад баримт бичгийг батлаагүй байна. Төв аймгийн ТЭЗ-ийн бөгөөд Засаг даргын 2021 онд Төв аймгийн төсвийн байгууллага, төсөл сангуудын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэхэд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан бөгөөд 2024 онд файлаар авсан тул тайлант онд энэхүү баримт бичгийг мөрдөж ажиллаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Дэлгэрхаан сум Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,444,355.7 мянган төгрөгөөр буюу 60,3 хувиар өссөн байна. Энэ нь Нутгийн удирдлагын ордны шинэ барилга ашиглалтад орж хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	680,398.3	77,488.6	-602,909.7
Авлага	356,381.5	416,614.9	60,233.4
Бараа материал	183,614.1	96,578.4	-87,035.7
Үндсэн хөрөнгө	1,176,788.7	3,250,856.5	2,074,067.8
Нийт хөрөнгө	2,397,182.6	3,841,538.4	1,444,355.8
Өр төлбөр	0.0	1,112,595.4	1,112,595.4
Засгийн газрын хувь оролцоо	2,397,182.7	2,728,943.0	331,760.3
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	2,397,182.7	3,841,538.4	1,444,355.7

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оноос дараах байдлаар өөрчлөгдсөн байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 77,488.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 602,909.7 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь шилжих үлдэгдлийг Нутгийн удирдлагын ордны шинэ барилгын ажлын санхүүжилд зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Авлага дансны үлдэгдэл 416,614.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 60,233.4 мянган төгрөгөөр өссөн нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага, хүү дутуу бүртгэснийг нэмж бүртгэснээс мөн Орон нутгийн хөгжлийн сангийн дуусаагүй ажил, хүлээж аваагүй ажилтай холбоотойгоор өссөнөөс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 96,578.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 87,035.7 мянган төгрөгөөр буурсан нь сумын түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой зарцуулалт нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 3,250,856.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,074,067.8 мянган төгрөгөөр өссөн нь Орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлууд нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Өглөг дансны үлдэгдэл 1,112,595.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,112,595.4 мянган төгрөгөөр өссөн нь Нутгийн удирдлагын ордны шинэ барилгыг гүйцэтгэсэн компани өөрийн хөрөнгөөр барьж санхүүжилт 935,262.2 мянган төгрөг дутуу өгсөн, мөн аймгаас 170,795.1 мянган төгрөгийн санхүүжилт илүү өгсөн тус нөлөөлсөн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 2,728,943.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 331,760.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 77,488.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 602,909.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Банканд байгаа бэлэн мөнгө	680,398.3	77,488.6	-602,909.7
Төрийн сангийн харилцах	663,266.7	62,634.0	-600,632.7
Арилжааны банк дахь харилцах	17,131.6	14,854.6	-2,277.0
Дүн	680,398.3	77,488.6	-602,909.7

Эх сурвалж: Дэлгэрхаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны 62,634.0 мянган төгрөгийн 63,9 хувь буюу 40,000.0 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сан, 22,6 хувь буюу 14,144.9 мянган төгрөгийг Орон нутгийн ерөнхий орлого, 10,1 хувь буюу 6,339.1 мянган төгрөгийг Хоршоо хөгжүүлэх сан, 3,4 хувь буюу 2,150.0 мянган төгрөгийг БНСБС-ийн дансны үлдэгдэл эзэлж байна. Арилжааны банк дахь харилцах дансны 14,854.6 мянган төгрөгийн үлдэгдлийг Эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл эзэлж байна.

Аудитын илрүүлэлт

1. Цалингийн зардлын зарцуулагдаагүй үлдэгдлийн 3,905.0 мянган төгрөгийг ЗДТГ, 1,553.9 мянган төгрөгийг ИТХ ерөнхий дансанд төвлөрүүлээгүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

2. Улс төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг ЗДТГ 17,154.6 мянган төгрөг, ИТХ 4,085.3 мянган төгрөг тус тус илүү олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

3. ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгэлтэй 0200 УНӨ дугаар бүхий Прадо120 маркийн машиныг шилжүүлэн аваагүй, 420.0 мянган төгрөгийн торгуулийг төлөөгүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

4. Сумын Эмийн эргэлтийн сангийн хөрөнгөнөөс ЭМТ-ийн барилгын засварт 16,000.0 мянган төгрөгийг Тарамцаг хайрхан ХХК-д шилжүүлж, зориулалтын бус зарцуулсанд төлбөрийн акт бичигдсэн.

5.ЗДТГ-ын харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтын цахим баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс 115,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй зөрчилд албан шаардлага бичив.

6. Шинэ хөдөө төслийн хүрээнд нийлүүлэгдсэн трактор, үр тарианы үрлүүр, хаман боогч хүлээн авч хөрөнгийг түрээсээр ашиглуулсан бөгөөд үр дүнг тайлагнаагүй зөрчилд албан шаардлага бичигдсэн.

7. ЗДТГ сумын 100 жилийн ойн арга хэмжээнд зориулан 13,500.0 мянган төгрөгийн медаль тэмдэг авсан зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага бичигдсэн.

8. ЗДТГ хөрөнгийн зардлаас бараа материал бэлтгэсэн мөн бараа ажил үйлчилгээний зардлаас хөрөнгө бэлтгэсэн 87,919.5 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

9. ЗДТГ нь Үндсэн хөрөнгийн тодруулгын тайлангийн худалдан авсан дүнг мөнгөн гүйлгээний тайлангийн хөрөнгийн зардалтай тулгахад 744,409.6 мянган төгрөгөөр зөрүүтэй байсныг аудитын явцад залруулав.

10. ЗДТГ-ын үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг зэрэгцүүлэн тулгахад цалин, НДШ, тогтмол зардал 4,878.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан алдааг аудитын явцад залруулсан.

11. ИТХ-ын нэмэлт санхүүжилтийн дансны татан төвлөрүүлсэн дүнгээр төсвийн тохируулгыг давхардуулан е тайланд тайлагнасныг аудитын явцад залруулав.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 356,381.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 92,540.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган

төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+) Бууралт(-)
Дансны авлага	356,381.5	416,614.9	60,233.4
Байгууллагаас авах авлага	7,778.3	7,192.0	-586.3
Хувь хүмүүсээс авах авлага	348,603.2	409,422.9	60,819.7
Дүн	356,381.5	416,614.9	60,233.4

Эх сурвалж: Дэлгэрхаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны жилийн эцсийн үлдэгдэл 416,614.9 мянган төгрөгийн 98,3 хувийг хувь хүмүүсээс авах авлага, 1,7 хувийг байгууллагаас авах авлага эзэлж байна. Хувь хүмүүсээс авах авлагын 81,4 хувь буюу 339,256.9 мянган төгрөг нь Хоршоо хөгжүүлэх сангийн, байгууллагаас авах авлагын 97,3 хувь буюу 7,000.0 мянган төгрөгийн авлага нь ЗДТГ-ын өвс, тэжээлийн авлагын үлдэгдэл эзэлж байна.

Авлага дансны үлдэгдэл 416,614.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 60,233.4 мянган төгрөгөөр өссөн нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн хүү дутуу бүртгэснийг нэмж

бүртгэснээс мөн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлын гүйцэтгэл дутуугаас шалтгаалан авлага өссөн байна.

Аудитын илрүүлэлт

1.Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлагын үлдэгдлийг авлагын тодруулга тайланд 5 жилээс дээших 339,257.0 мянган төгрөгийн авлагыг насжилтаар зөв ангилаагүй зөрчлийг аудитын явцад залруулав.

2.Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлагын судалгаанд тайлант оны үлдэгдэлд хүүгийн авлага тооцсон дүнгээс үр дүнгийн тайланд 13,993.0 мянган төгрөгөөр тусгасныг аудитын явцад залруулав.

3. Монгол банкны мэдээллийн санд Хоршоо хөгжүүлэх сангийн 46 зээлдэгчийн зээлийн авлагын үлдэгдэл 339,257.0 мянган төгрөгийг мэдээлээгүй, зээлийн эргэн төлөлт хариуцлагагүй хандсан зөрчилд зөвлөмж өгөв.

4. Хоршоо хөгжүүлэх сангийн үр дүнгийн тайланд үндэслэлгүй бараа ажил үйлчилгээний зардал 21,677.2 мянган төгрөгөөр бууруулсныг аудитын явцад залруулсан.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данс үлдэгдэлгүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 96,578.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 87,035.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/мянган

төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+) Бууралт(-)
Түүхий эд материал	33,362.4	22,584.6	-10,777.8
Эм боох материал	33,362.4	22,584.6	-10,777.8
Хангамжийн материал	150,251.7	54,993.8	-95,257.9
Бичиг хэргийн материал	85.0	56.5	-28.5
Аж ахуйн материал	30,533.5	8,449.8	-22,083.7
Сэлбэг хэрэгсэл	3,389.0	0.0	-3,389.0
Түлш шатах томлох материал		250.0	250.0
Бусад хангамжийн материал	97,244.2	46,237.5	-51,006.7
Мал амьтад	19,000.0	19,000.0	0.0
Дүн	183,614.1	96,578.4	-87,035.7

Эх сурвалж: Дэлгэрхаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны үлдэгдэл 96,578.4 мянган төгрөгийн 75,7 хувийг ЗДТГ, 23,4 хувийг эмийн эргэлтийн сан, 0,9 хувийг ИТХ-ын бараа материал эзэлж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 96,578.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 87,035.7 мянган төгрөгөөр буурсан нь сумын түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой зарцуулалт нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

1. ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр болон шинэ хөдөө төслийн хүрээнд өндөр ашиг шимтэй ухна, хуц, бух зэрэг 19,500.0 мянган төгрөгийн малыг малчдад гэрээгээр эзэмшүүлсэн гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй зөрчилд зөвлөмж өгсөн.

2. ЗДТГ-ын жилийн эцсийн тооллогын дүн санхүүгийн тайлангийн бараа материалын эцсийн үлдэгдлээс 7,574.8 мянган төгрөгөөр зөрүүтэй зөрчилд тооллогын комиссын үүрэг хариуцлагыг сайжруулах, тооцоо бодолтын үр дүнг удирдлагад танилцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөө.

3. Тайлант онд 5 ААН, иргэнээс худалдаж авсан бараа материалыг орлогод аваагүй 5,081.7 мянган төгрөгийг алдааг аудитын явцад залруулсан байна.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө үлдэгдэлгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 3,250,856.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,074,067.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган

төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+) Бууралт(-)
Биет хөрөнгө	1,175,824.8	3,206,976.6	2,031,151.8
Барилга, байгууламж, орон сууц	698,803.5	2,242,675.7	1,543,872.2
Авто-тээврийн хэрэгсэл	72,482.1	192,233.1	119,751.0
Машин тоног төхөөрөмж(компьютер)	37,299.9	49,642.8	12,342.9
Зам, гүүрний байгууламж	86,614.9	80,094.2	-6,520.7
Тавилга, аж ахуйн эд хогшил	12,513.0	39,485.5	26,972.5
Бусад үндсэн хөрөнгө	268,111.4	602,845.3	334,733.9
Биет бус хөрөнгө	964.0	43,879.9	42,915.9
Программ хангамж	525.0	487.5	-37.5
Бусад биет бус хөрөнгө	439.0	43,392.4	42,953.4
Дүн	1,176,788.8	3,250,856.5	2,074,067.7

Эх сурвалж: Дэлгэрхаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдлийн 99,84 хувь буюу 3,245,807.9 мянган төгрөгийг ЗДТГ, 0,11 хувь буюу 3,695.7 мянган төгрөгийг Эмийн эргэлтийн сан, 0,04 хувь буюу 1,353.0 мянган төгрөгийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 3,250,856.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,074,067.7 мянган төгрөгөөр өссөн. Энэ нь аймаг, орон нутгийн хөрөнгө оруулалтаар Нутгийн удирдлагын ордны шинэ барилга 1,566,018.1 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаар баяр наадмын асар 178,898.5 мянган төгрөг, аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалт, хандиваар сумын төвийн өндөрлөг, хаяг, 5-10 ханатай 5 гэр, өв соёлын өргөөний цомцог гэр 121,600.0 мянган төгрөг, төсвийн хөрөнгө оруулалтаар сийлбэртэй иж бүрэн гэр, хүлээлгийн сандал, компьютер 55,674.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй орлогоор трактор иж бүрдэл 133,818.6 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт:

1. ЗДТГ нь байгууллагын санхүүгийн тайлан дахь бүртгэлээс 22 газрын мэдээлэл бүртгэлд дутуу 78,080.0 мянган төгрөгөөр зөрүүтэй зөрчилд зөвлөмж өгсөн.
2. ЗДТГ нь нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг үндсэн хөрөнгийн бусад хөрөнгөнд бүртгэж элэгдэл байгуулсан, бусад хангамжийн материалд бүртгэсэн 35,014.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.
3. ЗДТГ-ын санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл жилийн эцсийн тооллогын дүнгээс зөрүүтэй зөрчилд тооллогын комиссын үүрэг хариуцлагыг сайжруулах, тооцоо бодолтын үр дүнг удирдлагад танилцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.
4. Гэр хорооллын айл өрх, үйлчилгээний байгууллагуудын нэгдсэн халаалтын системд холбоход хийгдсэн 65,574.0 мянган төгрөгийн ажлыг данс бүртгэл тусгаагүй зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.
5. Сумын ЗДТГ-ын барилга хүлээн авсан улсын комиссын акт гарсан байхад 630,755.8 мянган төгрөгөөр хөрөнгийг орлого аваагүй алдааг аудитын явцад залруулсан.
6. ЗДТГ нь шинэ хөдөө төслийн хүрээнд нийлүүлэгдсэн трактор, үр тарианы үрлүүр, хаман боогч 133,818.6 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэл тусгаагүй алдааг аудитын явцад залруулж бүртгэсэн.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 1,112,595.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,112,595.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган

төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+) Бууралт(-)
Өглөг	0	1,112,595.4	1,112,595.4
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0	5,261.4	5,261.4
Байгууллагад төлөх өглөг	0	1,107,334.0	1,107,334.0
Дүн	0	1,112,595.4	1,112,595.4

Эх сурвалж: Дэлгэрхаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт:

Аудитаар илэрсэн алдаа зөрчилгүй байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,397,182.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,863,899.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган
төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+) Бууралт(-)
Засгийн газрын хувь оролцоо	5,261,082.6	2,397,182.7	-2,863,899.9
Засгийн газрын оруулсан капитал	1,624,609.5	579,464.8	-1,045,144.7
Хуримтлагдсан үр дүн	1,653,746.2	1,506,702.5	-147,043.7
Өмнөх үеийн үр дүн	65,344.3	4,392,935.9	4,327,591.6

Тайлант үеийн үр дүн	1,588,401.9	-2,886,233.4	-4,474,635.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,982,726.9	311,015.4	-1,671,711.5
Дүн	5,261,082.6	2,397,182.7	-2,863,899.9

Эх сурвалж: Дэлгэрхаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 2,397,182.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,863,899.9 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих ЕБС, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төвийн байгууллагуудын авлага, засгийн газрын сан, дахин үнэлгээний нэмэгдлийг өмнөх үеийн үр дүн дансанд хааж, тайлант оны үр дүн 2,863,899.9 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт:

Хоршоо хөгжүүлэх сангийн тайланд тайлант оны үр дүнг алдаатай тайлагнасныг аудитын явцад залруулсан.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 2,147,311.0 мянган төгрөг, нийт зарлагыг 2,147,311.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 357,885.2 мянган төгрөгөөр бууруулж, сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 7 тоот тогтоолоор 1,789,425.9 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнээс урсгал зардлыг 1,375,999.8 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 413,426.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь төсөв захирагч төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй ба цалин, урсгал засвар, шатахуун, албан томилолтын зардлыг бууруулснаас шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Дэлгэрхаан сумын ИТХ-ын 2023 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 01 тоот тогтоолоор 2023 оны батлагдсан төсвийг 2,269,812.9 мянган төгрөгөөр нэмж, 4,059,238.8 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна. Нэмэгдсэн орлогын эх үүсвэрийг задалбал татварын орлого ан агнах зөвшөөрлийн хураамж 1,086,956.4 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн шилжих үлдэгдэл 540,583.2 мянган төгрөгөөр, хандив 550,290.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 8. Орлого, эх үүсвэрийн төлөвлөгөө

/мянган төгрөгөөр/

Орлого, эх үүсвэрийн үзүүлэлтүүд	Төсөв баталсан ИТХ-ын тогтоол		Нэмэгдсэн зөрүү
	2022.12.19 №07	2023.08.22 №01	
Татварын орлого	747,666.7	1,823,263.1	1,075,596.40
Татварын бус орлого	89,400.0	109,209.5	19,809.50
Татварын болон татварын бус орлогын дүн	837,066.7	1,932,472.6	1,095,405.90
Сумын төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	573,245.1	597,084.5	23,839.40
Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг	204,348.1	264,042.2	59,694.10
Орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдэл	9,503.4	9,503.4	-
Шилжих үлдэгдэл	105,552.8	646,136.1	540,583.30
Сумын 100 жилийн хандив тусламжийн эх үүсвэр	59,709.8	610,000.0	550,290.20
Эх үүсвэрийн нийт дүн	1,789,425.9	4,059,238.8	2,269,812.90

Эх сурвалж: Дэлгэрхаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төлөвлөгөөгөөр татварын болон татварын бус орлогоор 1,932,472.6 мянган төгрөг, сумын төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 597,084.5 мянган төгрөг, сумын төсвийн урьд оны шилжих үлдэгдэл 646,136.1 мянган төгрөг, сумын орон нутгийн хөгжлийн санд аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэг 264,042.2 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр 202,301.8 мянган төгрөгийн нийт 4,261,540.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 483,039.0 мянган төгрөгийн санхүүжилт, сумын төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 762,134.1 мянган төгрөг, сумын орон нутгийн хөгжлийн санд аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэг 257,432.2 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдлээс 9.5 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөр 6,235.1 мянган төгрөгийн нийт 2,330,562.8 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, 1,930,977.8 мянган төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна.

Хүснэгт 9. Орлого, эх үүсвэрийн гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Орлого, эх үүсвэрийн үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Татварын орлого	1,823,263.1	481,823.9	(1,341,439.2)
Татварын бус орлого	109,209.5	1,215.1	(107,994.4)
Татварын болон татварын бус орлогын дүн	1,932,472.6	483,039.0	(1,449,433.6)
Сумын төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	597,084.5	762,134.1	165,049.6
Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг	264,042.2	257,432.2	(6,610.0)
Орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдэл	9,503.4	9,503.4	-
Шилжих үлдэгдэл	646,136.1	646,552.9	416.8
Сумын 100 жилийн хандив тусламжийн эх үүсвэр	610,000.0	171,901.2	(438,098.8)
Хоршоо хөгжүүлэх сан	202,301.8	6,235.1	(196,066.7)
Эх үүсвэрийн нийт дүн	4,261,540.6	2,330,562.8	(1,930,977.8)

Эх сурвалж: Дэлгэрхаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг сумын ИТХ-ын хуралдаанаас 1,932,472.6 мянган төгрөгөөр тодотгон баталсан. Гүйцэтгэлээр нийт 483,039.0 мянган төгрөгийн татварын ба татварын бус орлогыг төвлөрүүлж, батлагдсан төлөвлөгөөг нийт дүнгээр 1,449,433.6 мянган төгрөгөөр буюу 75,0 хувиар тасалсан байна.

Орлогыг нэр төрлөөр нь задалбал агнуурын нөөц ашигласны төлбөр 1,471,304.8 мянган төгрөг буюу 84,1 хувиар, түрээсийн орлого 500.0 мянган төгрөг буюу 100,0 хувиар, хүү торгууль 900.0 мянган төгрөг буюу 100,0 хувиар, галт зэвсгийн албан татвар 230.0 мянган төгрөг буюу 46,0 хувиар, малын тоо толгойн албан татвар 11,361.9 мянган төгрөг буюу 33,1 хувиар, иргэдийн хадгаламжийн хүүгийн орлого 4,780.0 мянган төгрөг буюу 23,9 хувиар, суутган-2 татвар 123.3 мянган төгрөг буюу 1,4 хувиар, үйл ажиллагааны орлого 262.0 мянган төгрөг буюу 5,3 хувиар тус тус тасарсан байна.

Сумын төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 597,084.5 мянган төгрөг баталснаас гүйцэтгэлээр 762,134.1 мянган төгрөг олгож, дамжуулан зээлээр 165,049.6 мянган төгрөгийг олгосон байна.

Сумын 100 жилийн хандиваар 610,000.0 мянган төгрөгийн хандивын орлого батлагдсанаас гүйцэтгэлээр 171,901.2 мянган төгрөг буюу 28,2 хувийн эх үүсвэр бүрдүүлсэн байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн батлагдсан төлөвлөгөөгөөр 202,301.8 мянган төгрөгийн эргэн төлөлт төвлөрүүлэхээс 6,235.1 мянган төгрөг бүрдүүлж 196,066.7 мянган төгрөгийн буюу 3,1 хувийн эх үүсвэр бүрдүүлсэн байна.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын 2023 онд тодотгон батлагдсан зардлын төлөвлөгөө 4,261,540.6 мянган төгрөг, зардлын нийт гүйцэтгэл 2,287,025.9 мянган төгрөг буюу 1,974,514.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулж, гүйцэтгэл 53,7 хувьтай байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар тайлант онд цалин, шимтгэлийн зардал 31,083.0 мянган төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 11,463.3 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 600.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, төлбөр хураамжийн зардал 313,6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 332,616.5 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардал 1,395,481.4 мянган төгрөгөөр, эргэж төлөгдөх цэвэр зээл 202,301.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн гүйцэтгэх засаглал хөтөлбөрийн /70106 /	2,672,107.9	1,402,272.4	1,269,835.5	52.5
2	ОН-ын өөрөө удирдах ёсны байгууллага хөтөлбөрийн /70105/	73,968.9	73,968.8	0.1	100.0
3	Ерөнхий боловсрол хөтөлбөрийн /71802/	233,875.4	233,275.4	600.0	99.7
4	Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн /71801/	41,183.8	41,183.8	-	100.0
5	Эмнэлгийн тусламж үйлчилгээ хөтөлбөрийн /71602/	50,086.8	48,069.9	2,016.9	96.0
6	Соёл урлаг хөтөлбөрийн /71702/	70,168.8	66,997.3	3,171.5	95.5
7	Орон нутгийн хөгжлийн сан	917,857.6	421,258.3	496,599.3	45.9
8	Хоршоо хөгжүүлэх сан	202,301.8	-	202,301.8	-
Нийт дүн		4,261,551.0	2,287,025.9	1,974,525.1	53.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нэмэлт санхүүжилтийн тайланд дээд шатны төсөв захирагчаас 106,713.5 мянган төгрөг,

төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 15,950.4 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдсэнээс төрийн захиргааны албан хаагчийн нэмэгдэл цалин, шимтгэлд 24,359.0 мянган төгрөг, инженерийн шугам сүлжээний ажлын хүрээнд гэр хорооллыг шугамд холбох ажлын эхний санхүүжилтэд 65,573.9 мянган төгрөг, бараа ажил үйлчилгээний бусад зардалд 21,822.9 мянган төгрөгийн тус тус зарцуулсан байна. Үүнээс 104,033.1 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 10,608.0 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 8 хөтөлбөрийн 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 11. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	/мянган төгрөгөөр/	
					Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2023.01.01 2023.12.31	Сумын ИТХТ, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах, мэргэшсэн тогтвортой өндөр чадавх бүхий аппарат бүрдүүлж, хуралдааныг зохион байгуулж, мэдээллээр тасралтгүй хангахад оршино. Жилд 4-өөс доошгүй удаа хурал хийнэ.	Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах, мэргэшсэн тогтвортой өндөр чадавх бүхий аппарат бүрдүүлж, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын, ээлжит хуралдааныг 4 удаа, ээлжит бус хуралдаанг 1 удаа зохион байгуулж 27 асуудал хэлэлцэж хэрэгжилт 90%, байгууллагын гүйцэтгийн төлөвлөгөө 97.1%-тай тус тус хэрэгжсэн байна.	73,969.0	73,968.8
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01 2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 41 зорилт, хэрэгжүүлэх 118 арга хэмжээ хэрэгжүүлэх	Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 41 зорилт, 118 хэрэгжүүлэх арга хэмжээтэй боловсруулан баталж хэрэгжилт 98.22% -тай хэрэгжсэн байна.	2,672,107.8	1,402,272.4
3	70106-Хоршоо хөгжүүлэх сан	2023.01.01 2023.12.31	Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13 ны өдрийн А/361 дугаар тушаалаар батлагдсан "Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлтэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ыг мөрдөж ажиллах	"Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлтэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ыг мөрдөн ажиллаж 2023 онд 7 иргэний 6.2 төгрөгийн зээл, зээлийн хүү төвлөрүүлэн ажилласан. Хугацаа хэтэрсэн зээлийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд бүртгэсэн.	202,301.8	-
			ХХС-аас иргэн, хоршоонд олгох зээлийг журмын дагуу шаардлага хангасан төсөл шалгаруулан зээл олгох	Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгох төсөл хөтөлбөр зээлийн сонгон шалгаруулалт зарлагдаж тэнцсэн материал ирүүлээгүй учир зээл олгоогүй.		
4	71802-Ерөнхий боловсролын сургууль	2023.01.01 2023.12.31	Ерөнхий боловсрол сургууль нь 6 зорилт 27 арга хэмжээ хэрэгжүүлэх	2022-2023 оны хичээлийн жилд нийт 252 суралцагчтай хичээл сургалтын үйл ажиллагаа явуулсан байна. Энэ хичээлийн жилд бага боловсролд 215 суралцагч хамрагдахаас 147 суралцагч хамрагдаж хамран сургалт 68.4%, суурь боловсролд 130 суралцагч хамрагдахаас 79 суралцагч хамрагдаж хамран сургалт 60%, 6 настай 40 суралцагч хамрагдахаас 30 хүүхэд хамрагдаж хамран сургалт 75%, мэргэжлийн багшийн хангалт 100%-тай байна. Мэргэжлийн зэрэгтэй багш нийт багшийн 84.6%-ийг эзэлж байна. 2023 онд О.Намнандоржийн нэрэмжит ерөнхий боловсролын сургууль гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилт, 27 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн хэрэгжилт 90%-тай. 2023 онд "Багшийн гүйцэтгэлийн үнэлгээ" сургуулийн дундаж 73,24%	233,875.4	233,275.4

5	71801-Сургуулийн өмнөх боловсрол	2023.01.01 2023.12.31	Сургуулийн өмнөх боловсрол нь 3 зорилт 37 арга хэмжээ хэрэгжүүлэх	2022-2023 оны хичээлийн жилд 2-5 настай нийт 195 хүүхдээс ердийн бүлэгт 111, хувилбарт сургалтад 64 хүүхэд хамруулж хамран сургалт 89%, үүнээс 5 настай 52 хүүхэд хамрагдахаас ердийн бүлэгт 30, хувилбарт сургалтад 8, өөр газарт 14 хүүхэд хамрагдаж хамран сургалт 73%, мэргэжлийн багшийн хангалт 100%-тай байна. Мэргэжлийн зэрэгтэй багш нийт багшийн 50%-ийг эзэлж байна. 2023 онд Дэгдээхэй цэцэрлэг гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилт, 37 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн хэрэгжилт 92.1 хувьтай. Багшийн гүйцэтгэлийн үнэлгээ цэцэрлэгийн дундаж 87.24%-тай.	41,183.8	41,183.8
6	71702-Соёлын үйлчилгээ	2023.01.01 2023.12.31	Соёлын төв нь 4 зорилт 13 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 96%	70,168.8	66,997.3
7	71602-Эрүүл мэндийн төв	2023.01.01 2023.12.31	Нийт 8 төрлийн үзлэгт 2247 хүн, Эрүүл мэндийн даатгалын 4 багцын тусламж үйлчилгээнд 364 иргэдийг хамруулна.	Урьдчилан сэргийлэх үзлэгээс артерийн даралт ихсэлт 1119 хамрагдахаас 645 хамрагдаж 57.6%, чихрийн шижин 660 хамрагдахаас 321 хамрагдаж 38.6%, хөхний үзлэг 369 хамрагдахаас 249 хамрагдаж 67.4%, умайн хүзүүний эрт илрүүлэг 99 хамрагдахаас 46 хамрагдаж 46.4% буюу нийт 2247 хамрагдахаас 1261 хамрагдаж 56.1% байна ЭМД-ын 4 багцын тусламж үйлчилгээний өдрийн эмчилгээний багц 22, оношилгоо шинжилгээний багц 126, яаралтай тусламж 81, хэвтэн эмчилгээ 75, дуудлага ойрын 34, алсын дуудлага 2, шүдний эмчилгээ 185, нийт 525 иргэн тус тус хамрагдсан	50,086.8	48,069.9
8	70106-Орон нутгийн хөгжлийн сан	2023.01.01 2023.12.31	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шинээр хэрэгжих 4 төслийг 264,042.2 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэнэ.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 3, дутуу урьдчилгаа өгсөн 1 ажил байна. Хэрэгжилт 82.5%	917,857.6	421,258.3
Нийт дүн					4,261,551.0	2,287,025.9

Хэрэгжилт нь дутуу болон хангалтгүй байгаа төсөл хөтөлбөрийн шалтгаан нөхцөл байдлын талаар авч үзэхэд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх санхүүжилт дутуу хийгдсэн нөлөөлсөн байна.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг дарга 2023 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 37 хэрэгжүүлэх арга хэмжээг тусган төлөвлөгөөг баталсан байна. Үүнээс:

-Орон нутгийн урсгал зардлаар 13 арга хэмжээ төлөвлөж 7 ажил 6 бараа үйлчилгээ худалдан авахаар тусгасан. Ерөнхий гэрээ байгуулах журмаар 1 арга хэмжээ гэрээ байгуулж, тендер шалгаруулалтын онцгой журам-харьцуулалтын аргаар 4 тендер шалгаруулалтыг заасан хугацаанд цахим хэлбэрээр зохион байгуулж гэрээ байгуулан хэрэгжилтийг ханган ажилласан байна.

-Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 3 арга хэмжээ тусгаснаас 1 арга хэмжээг тендер шалгаруулалтын онцгой журам-харьцуулалтын аргаар цахим тендер шалгаруулалтыг зохион байгуулж Мандах оройн товгор ХХК-тай гэрээ байгуулан ажил гүйцэтгэж ашиглалтад хүлээн авсан байна. Сур харвааны хэрэгсэл авах ажлыг шууд худалдан авалтаар зохион байгуулж шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авсан байна.

-Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр баяр наадмын асар барих 1 арга хэмжээг тусгаж нээлттэй тендер шалгаруулалтын журмаар цахим тендер зохион байгуулсан байна. Энэхүү тендерт Үржих тээвэр ХХК үнийн санал ирүүлэн шалгарч ажил гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өгсөн.

-Байгаль хамгаалах сангийн санхүүжилтээр 3-н арга хэмжээ шууд худалдан авалтаар төлөвлөсөн байна. Байгаль хамгаалах сангийн санхүүжилт орж ирээгүй тул төлөвлөсөн арга хэмжээ хийгдээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Ц.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 3 дугаар сарын 25-ны өдөр цахимаар ирүүлсэн байна. Тус сумын санхүү албаны даргын үүрэгт ажлыг халамжийн мэргэжилтэн хавсарч гүйцэтгэж байгаа боловч санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд гаргаж ирүүлээгүй бөгөөд ЗДТГ-ын нягтлан бодогч нь нэгтгэсэн тайланг хийж, засгийн газрын санхүүгийн, төсвийн гүйцэтгэлийн э-тайланд шивж аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогчийн баталгаажуулсан цахим тайланд аудит хийлээ.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2023 оны батлагдсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг үзүүлэлтээр Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийн 2023 оны нийт зарлага 4,261,540.6 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 63,923.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75,0 хувиар буюу 47,942.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг дарга тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд шилэн дансны цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6.4.3-д заасан ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 2 ажлын тендер шалгаруулалтын мэдээлэл, 6.4.8-д заасан хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой шийдвэр, гэрээ нийт 456,812.5 мянган төгрөгийн, Эмийн эргэлтийн сангийн 32,216.2 мянган төгрөгийн 3 мэдээллийг хуулиар тогтоосон хугацаанд тус тус байршуулаагүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой, шилэн дансны үйл ажиллагаатай холбоотой 3 зөвлөмж өгөгдсөнийг 77,9% хэрэгжүүлэн Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 202 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн 01/271 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 12 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	120,368.3	3	93,825.8	77.9
Дүн	4	120368.3	3	93825.8	77.9

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн дараагийн аудитаар анхаарах асуудлаар 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн иргэдийн санал авсан байдал, тендер шалгаруулалт, хандив, зарцуулалттай холбоотой асуудлыг Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 1,449.2 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 1,449.2 мянган төгрөгийн алдааг залруулав.

1. Нэгтгэсэн санхүүгийн тайланд Хоршоо хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдлийг Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны хяналт, шалгалтаар баталгаажуулсан дүнгээс зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 2,609,196.7 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 7,000.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 2,602,196.7 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж хүргүүлсэн.

5.2 Төлбөрийн акт

Илрүүлэлт:

1. Дэлгэрхаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь авлагын үлдэгдэл 2021 оны өвсний авлагын 7,000.0 мянган төгрөгийг Хүүлэй хааны хишиг ХХК-аас авч барагдуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 тоот тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.3 Албан шаардлага

Албан шаардлагагүй болно.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Татварын болон татварын бус орлогын гүйцэтгэлтэй холбоотой

Илрүүлэлт:

1. Дэлгэрхаан сумын ИТХ-ын тогтоолоор 13 нэрийн орлого татварын болон татварын бус орлого 1,932,472.6 мянган төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр 8 нэрийн орлого 1,489,462.3 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “толилуулга”, “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж

Төсвийн орлогын бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлж нэр төрлөөр бүрэн биелүүлэх талаар үр дүнд хүрч ажиллах

2. Төсвийн төлөвлөлт гүйцэтгэлтэй холбоотой

Илрүүлэлт:

2. Дэлгэрхаан сумын ИТХ-ын тогтоолоор татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг 1,932,472.6 мянган төгрөгөөр баталсан нь аймгийн Татварын хэлтсийн мэдээнээс 1,109,255.6 мянган төгрөгөөр дутуу зөрүүтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 41 дүгээр зүйлийн 41.2.4-д “төсвийн сар, улирлын хуваарийг баримталж ажиллах” гэж заасны болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж

Татварын болон татварын бус орлогын мэдээг зөрүүтэй мэдээлдэг зөрчлийг арилгаж, мэдээний үнэн зөв байдалд тавих хяналтыг сайжруулах

Илрүүлэлт:

3. Аймгийн Татварын хэлтсийн ирүүлсэн мэдээг санхүүгийн нэгтгэсэн тайлангийн орлогын тодруулгатай тулган шалгахад 33.4 мянган төгрөгөөр зөрсөн нь э тайлангийн дүн мэдээнээс 3 нэрийн орлого 1,755.9 мянган төгрөгөөр илүү 3 нэрийн орлого 1,722.8 мянган төгрөгөөр дутуу тус тус зөрүүтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 41 дүгээр зүйлийн 41.2.4-д “төсвийн сар, улирлын хуваарийг баримталж ажиллах” гэж заасны болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж

Татварын болон татварын бус орлогын мэдээг зөрүүтэй тайлагнадаг зөрчлийг арилгаж, санхүүгийн ажилтны үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх талаар үр дүнд хүрсэн ажил зохион байгуулах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан-тай холбоотой		НББ-ийг буруу хэрэгжүүлсэн		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
									Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	1	1,449.1					1	1,449.1	1	1,449.1				
Засаг даргын тамгын газар	5	1,518,944.4	1	133,818.6	1	630,755.9	3	754,369.9	5	1,518,944.4				
Дүн	6	1,520,393.5	1	133,818.6	1	630,755.9	4	755,819.1	6	1,520,393.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Засаг дарга	4	2,609,196.7	1	7,000.0			3	2,602,196.7				
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	3	66,066.5	2	5,639.1			1	60,427.4				
Засаг даргын тамгын газар	14	443,641.8	3	21,479.5	3	202,919.5	7	205,742.8	1	13,500.0		
Хоршоо хөгжүүлэх сан	1	331,572.7					1	331,572.70				
Эмийн эргэлтийн сан	2	48,216.2	1	16,000.0	1	32,216.2						
Дүн	24	3,498,693.9	7	50,118.6	4	235,135.7	12	3,199,939.6	1	13,500.0	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Орон нутгийн хөгжлийн сан	1	456,812.5					1	456,812.5
Дүн	1	456,812.5					1	456,812.5
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	456,812.5	-	-	-	-	1	456,812.5

Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
	Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Өөрчлөлттэй		
		санал дүгнэлт гаргах	Түүвэрт хамрагдах	Аудит хийгээгүй		Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
1	2	3	4	5	6	7	8	9
Төсвийн шууд захирагч	2	1	1			1		
Орон нутгийн тусгай сан	4		4					
Төсвийн төвлөрүүлэн захирагч	1	1				1		
Дүн	7	2	5	-	-	2	-	-